



УЛСЫН БҮРТГЭЛИЙН ЕРӨНХИЙ
ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2024 оны 12 сарын 27 өдөр

Дугаар 3710

Улаанбаатар хот

П.Мөнхбаатарт сахилгын
шийтгэл ногдуулах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Төрийн албаны ёс зүйн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төрийн албаны тухай хуулийн 37 дугаар зүйлийн 37.1.6, 48 дугаар зүйлийн 48.1.1, Улсын бүртгэлийн ерөнхий хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.7 дахь заалт, Монгол Улсын сайд, Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Төрийн албаны зөвлөлийн даргын 2019 оны 36/32 дугаар хамтарсан тушаалаар батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчид сахилгын шийтгэл ногдуулах, түүнд гомдол гаргах журам”-ын 1.3.1, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын 2023 оны А/1716 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 10.1 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Баянзүрх дүүргийн Улсын бүртгэлийн хэлтсийн дарга Пионерийн Мөнхбаатар нь төрийн албан хаагчийн нийтлэг үүргийг зөрчсөн нь. Ёс зүйн дэд хорооны 09 дүгээр сарын 24-ний өдрийн хурлын дүгнэлтээр тогтоогдсон тул түүнд 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрөөс “өөрт нь ганцаарчилсан хэлбэрээр сануулах” сахилгын шийтгэл ногдуулсугай.

2. Өдөр тутмын үйл ажиллагаанд хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, хариуцлагатай хандахыг П.Мөнхбаатарт үүрэг болгосугай.

3. Албан хаагчдад ажлын хариуцлага, дэг журмыг сахин ажиллахыг анхааруулж, арга зүйн удирдлагаар хангаж ажиллахыг Нийслэлийн Улсын бүртгэлийн газар (Г.Анхныбаяр)-т, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Тамгын газар (Д.Давааням)-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаалыг эс зөвшөөрвөл тушаалыг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор төрийн албаны төв байгууллагад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙН
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

У.БОЛДХҮҮ



142407929